



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/01

Цагаан-Уул сум

Шалгарсан төслүүдийг санхүүжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Сайдын А/521 тоот тушаалын “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх журам”, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2023 оны 11 дүгээр сарын 22-ны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах комиссын шийдвэрээр шалгарсан төслийг санхүүжүүлэх, зээлийг олгох ажлыг зохион байгуулж төсөлд шаардагдах материалуудыг бүрэн болгохыг хүнс, хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн /М.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.

2. Хотгойд элгэн нутаг хоршооны “Хог биш баялаг бүтээе” төсөл 40 сая төгрөг, Бадрал бум хоршооны “Арьсаар урлахуй” төсөл 10,0 сая төгрөг, Аварга тэс хоршооны “Арьс нэхий боловсруулах” төсөл 31.680.000 төгрөг, Маяг саяг хоршооны “Авто засвар” төсөлд 20 сая төгрөг тус тус олгохыг зөвшөөрсүгэй.

3. Сангийн хөрөнгийг зориулалтын бус, үр ашиггүй зарцуулсан нь энэ журмын 7.1-т заасан зохистой харьцааны шалгуур хангаагүй болон эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалтаар тогтоогдсон бол Төсөв, санхүүгийн болон Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтарсан шийдвэрээр сангийн хөрөнгийг татан төвлөрүүлэн дахин хуваарилж ажиллахыг хоршоо хөгжүүлэх сангийн төслийн хяналтын (комисс)-д даалгасугай.

4. Хоршоо хөгжүүлэх сангаас авсан зээлээ үр дүнтэй ашиглаж, бизнесээ өргөжүүлэн тайлан мэдээг цаг тухайд нь гаргаж Хүнс, хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн (М.Оюунчимэг)-т хүлээлгэн өгөхийг төсөл хэрэгжүүлэгч (Хотгойд элгэн нутаг хоршооны П.Чулуунбат), (Аварга тэс хоршооны В.Баасанрагчаа), (Бадрал бум хоршооны Ё.Цэцэгмаа), (Маяг саяг хоршооны Б.Мягмаржав), нарт даалгасугай.

5. Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авч төсөл хэрэгжүүлж байгаа зээлдэгчийн материалтай танилцаж зээл олгохыг Хоршоо хөгжүүлэх сангийн нягтлан /Ж.Пүрэвжав/-д зөвшөөрсүгэй.